



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 10 сарын 03 өдөр

Дугаар A/504

Мөрөн сум

Захирамж хүчингүй болгох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.11, 66 дугаар зүйлийн 66.1, 66.3, Газрын тухай хуулийн 61 дүгээр зүйлийн 61.1, Захиргааны ерөнхий хуулийн 26 дугаар зүйлийн 26.1, 26.2, 27 дугаар зүйл, 40 дүгээр зүйлийн 40.2, 43 дугаар зүйлийн 43.1, Авлигатай тэмцэх газрын мөрдөгчийн 2023 оны 09 дүгээр сарын 20-ны өдрийн 107 тоот мэдэгдлийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Хөвсгөл аймгийн Мөрөн сумын 6 дугаар баг, Жаст ойлын хажууд байрлах "Худалдаа, нийтийн үйлчилгээний газар, төв, цогцолбор" зориулалттай 367 м.кв газрыг дуудлага худалдаа, төсөл сонгон шалгаруулалтгүйгээр хууль бусаар эзэмшүүлж, бусдад давуу байдал олгосон нь эрх бүхий байгууллагын дүгнэлтээр тогтоогдсон тул Хөвсгөл аймгийн Засаг даргын 2023 оны 08 дугаар сарын 17-ны өдрийн А/439 дүгээр захирамжийг хүчингүй болгосугай.

2. Уг захирамж гарсантай холбогдуулан Мөрөн сумын иргэн Цагаанчулууны Цолモンгийн газар эзэмших эрхийн гэрчилгээ, гэрээг хүчингүй болгож, газар эзэмшигчийн мэдээллийн сангаас хасалт хийхийг аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын дарга (Б.Ганзориг)-д даалгасугай.

3. Захиргааны актыг ажлын 5 хоногийн дотор эрх, ашиг сонирхол хөндөгдэж буй этгээдэд мэдэгдэж, баримтжуулсан захиргааны актыг хувийн хэрэгт бурдүүлэлт хийж ажиллахыг аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын дарга (Б.Ганзориг)-д үүрэг болгосугай.

4. Аймгийн Засаг даргын захирамжийг эс зөвшөөрвөл захирамжийг мэдэгдсэнээс хойш 30 хоногийн дотор шүүхэд гомдол гаргах эрхтэй болохыг дурдсугай.

5. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Э.Улам-Өсөх)-д үүрэг болгосугай.

ДАРГА

П.ЛХАГВАЖАВ



Захирамж-2023

6712011128